

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/091/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2025 он	Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: baasansurens@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12-13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13-14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-16
4. Аудитын тайлан	16-19
4.1 Ерөнхий зүйл	16-17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17-18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18-19
5. Аудитын илрүүлэлт	19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ДАРГА,
ХУРАНДАА Б. МӨНХЗУЛ ТАНАА

2025.02.14 № СЭА-2023/091/НА-СТА-ТЧЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос шалтгаалж тус газрын 2024 оны цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 27.9 хувиар нэмэгдсэн бөгөөд урсгал зардлын 83 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос төлөх эрүүл мэндийн даатгалын зардал эзэлж байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд тус газар нь хоригдол, хоригдогч нарын хоол хүнсний материалын худалдан авах ажиллагааг цахим системд харьцуулалтын аргаар зохион байгуулж, 2 удаа нээлттэй зар тавьсан боловч санал ирээгүй гэх үндэслэлээр цахим системд бүртгэлгүй хувь хүн болон аж ахуйн нэгжүүдтэй гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус газар нь тайлант оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 3 зорилтын хүрээнд 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	58,761,381.44	39,267,271.31
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	188,000.00	188,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	188,000.00	188,000.00
3121	Төгрөг	188,000.00	188,000.00
31211	Төрийн сангийн харилцах	188,000.00	188,000.00
33	АВЛАГА	-	4,620,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	4,620,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	58,573,381.44	34,459,271.31
351	Түүхий эд материал	32,903,201.01	23,770,177.01
35110	Тусгай зориулалттай материал	32,853,701.01	23,648,649.01
35130	Эм боох материал	49,500.00	121,528.00
354	Хангамжийн материал	25,670,180.43	10,689,094.30
35410	Бичиг хэргийн материал	1,040,200.00	580,000.00
35420	Аж ахуйн материал	11,461,140.00	7,029,740.00
35450	Барилгын засварын материал	-	12,500.00
35460	Хүнсний материал	2,274,049.60	1,519,834.30
35470	Бусад хангамжийн материал	10,894,790.83	1,547,020.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,233,226,694.24	1,357,079,691.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,233,226,694.24	1,357,079,691.37
392	Биет хөрөнгө	1,005,422,694.24	1,126,827,149.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	939,612,572.98	939,612,572.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	(120,964,803.76)	(145,227,905.80)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	256,818,399.85	288,218,399.85
39204	Хуримтлагдсан элэгдэл	(141,362,893.11)	(67,534,906.33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	157,324,001.60	185,154,931.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(103,132,246.33)	(108,066,274.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,704,867.00	54,982,367.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,899,861.59)	(26,377,059.35)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	3,746,324.00	3,746,324.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,912,000.00	3,912,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,335,666.40)	(1,593,299.68)
393	Биет бус хөрөнгө	227,804,000.00	230,252,541.67
39301	Программ хангамж	6,417,692.31	3,862,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,417,692.31)	(1,414,150.64)
39303	Бусад биет бус хөрөнгө	227,804,000.00	227,804,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,291,988,075.68	1,396,346,962.68
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,291,988,075.68	1,396,346,962.68
51	Засгийн газрын хувь оролцоо	1,291,988,075.68	1,396,346,962.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	345,578,539.48	345,578,539.48
51101	Өмч: - төрийн	345,578,539.48	345,578,539.48
512	Хуримтлагдсан үр дүн	376,864,085.85	481,222,972.85
51210	Өмнөх үеийн үр дүн	328,418,886.71	376,864,085.85
51220	Тайлант үеийн үр дүн	48,445,199.14	104,358,887.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	569,545,450.35	569,545,450.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,291,988,075.68	1,396,346,962.68

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,170,654,118.61	1,626,444,078.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	121,433,018.61	189,684,278.00
120	Нийтлэг татварын бус орлого	121,433,018.61	189,684,278.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	121,044,754.85	189,684,278.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,710,000.00	2,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	118,334,754.85	187,684,278.00
120009	Бусад орлого	388,263.76	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,049,221,100.00	1,436,759,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,049,221,100.00	1,397,739,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,049,221,100.00	1,397,739,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	39,020,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	29,020,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,122,208,919.47	1,522,085,191.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,122,208,919.47	1,522,085,191.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,063,714,150.80	1,468,173,079.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	789,864,130.45	1,095,735,998.74
210101	Үндсэн цалин	456,568,174.00	653,398,999.62
210102	Нэмэгдэл	286,789,793.45	442,336,999.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,703,163.00	-
210104	Урамшуулал	19,803,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,606,580.24	20,202,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,606,580.24	20,202,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,152,396.84	115,667,576.47
210301	Гэрэл, цахилгаан	13,938,553.84	15,621,404.47
210302	Түлш, халаалт	54,259,083.00	69,977,120.00
210303	Цэвэр, бохир ус	15,954,760.00	30,069,052.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,929,668.66	56,275,238.15
210401	Бичиг хэрэг	4,040,220.00	5,123,600.00
210402	Тээвэр, шатахуун	12,450,000.00	14,360,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	868,309.56	1,478,312.32
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,171,139.10	9,185,155.00
210408	Бараа материал акталсны зардал		25,888,170.83
2105	Нормативт зардал	45,685,715.62	50,857,276.46
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,579,870.00	2,375,891.16
210502	Хоол, хүнс	44,105,845.62	48,481,385.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,072,280.00	27,291,950.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000.00	-
210604	Урсгал засвар	19,822,280.00	27,291,950.00
2107	Томилолт, зочны зардал	2,038,000.00	1,585,100.00

210702	Дотоод албан томилолт	2,038,000.00	1,585,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,154,152.00	6,774,656.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,189,535.00	1,755,099.50
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225,184.00	172,064.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	80,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,554,500.00	4,644,500.00
210807	Газрын төлбөр	104,933.00	122,993.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,211,226.99	93,782,582.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,642,216.00	10,487,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,569,010.99	83,294,832.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,494,768.67	53,912,111.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,291,800.00	53,827,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,331,800.00	52,617,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	960,000.00	1,210,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,192,968.67	85,011.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,192,968.67	85,011.81
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,000.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	48,445,199.14	104,358,887.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	48,445,199.14	104,358,887.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,051,931,100.00	1,438,759,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,710,000.00	2,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,710,000.00	2,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,710,000.00	2,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,710,000.00	2,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,049,221,100.00	1,436,759,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,049,221,100.00	1,397,739,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,049,221,100.00	1,397,739,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	39,020,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	29,020,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,049,621,100.00	1,413,619,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,049,621,100.00	1,413,619,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	991,126,331.33	1,355,087,688.19
21	ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	806,082,446.93	1,115,938,698.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	789,864,130.45	1,095,735,998.74
210101	Үндсэн цалин	456,568,174.00	653,398,999.62

210102	Нэмэгдэл	286,789,793.45	442,336,999.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,703,163.00	-
210104	Урамшуулал	19,803,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,218,316.48	20,202,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,218,316.48	20,202,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,152,396.84	115,667,576.47
210301	Гэрэл, цахилгаан	13,938,553.84	15,621,404.47
210302	Түлш, халаалт	54,259,083.00	69,977,120.00
210303	Цэвэр, бохир ус	15,954,760.00	30,069,052.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,771,370.56	26,816,267.32
210401	Бичиг хэрэг	3,682,750.00	4,641,800.00
210402	Тээвэр, шатахуун	12,450,000.00	14,360,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	758,044.56	1,478,312.32
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,480,576.00	6,096,155.00
2105	Нормативт зардал	40,691,504.00	50,175,089.16
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,629,370.00	2,447,919.16
210502	Хоол, хүнс	39,062,134.00	47,727,170.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,363,980.00	28,100,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,291,700.00	369,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	264,000.00	-
210604	Урсгал засвар	19,808,280.00	27,730,450.00
2107	Томилолт, зочны зардал	2,038,000.00	1,585,100.00
210702	Дотоод албан томилолт	2,038,000.00	1,585,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,264,417.00	6,774,656.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,299,800.00	1,755,099.50
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225,184.00	172,064.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	80,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,554,500.00	4,644,500.00
210807	Газрын төлбөр	104,933.00	122,993.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,762,216.00	10,030,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,762,216.00	10,030,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,494,768.67	58,532,111.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,291,800.00	53,827,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,331,800.00	52,617,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	960,000.00	1,210,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,192,968.67	85,011.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,192,968.67	85,011.81
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,000.00	4,620,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,000.00	4,620,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,310,000.00	25,140,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,850,000.00	25,140,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,850,000.00	25,140,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,850,000.00	25,140,000.00

225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,850,000.00	25,140,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,850,000.00)	(25,140,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(540,000.00)	-
9	МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	728,000.00	188,000.00
10	МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	188,000.00	188,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,578,539.48	569,545,450.35	328,418,886.71		1,243,542,876.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	345,578,539.48	569,545,450.35	328,418,886.71	0.00	1,243,542,876.54
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
Тайлант үеийн үр дүн			48,445,199.14		48,445,199.14
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,578,539.48	569,545,450.35	376,864,085.85	0.00	1,291,988,075.68
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,578,539.48	569,545,450.35	425,309,284.99	0.00	1,291,988,075.68
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	345,578,539.48	569,545,450.35	376,864,085.85	0.00	1,291,988,075.68
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
Тайлант үеийн үр дүн			104,358,887.00		104,358,887.00
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,578,539.48	569,545,450.35	481,222,972.85	0.00	1,396,346,962.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,399,739,800.00	1,399,654,788.19	85,011.81	99.99
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,399,739,800.00	1,399,654,788.19	85,011.81	99.99
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,345,912,700.00	1,345,827,688.19	85,011.81	99.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,345,912,700.00	1,345,827,688.19	85,011.81	99.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	1,095,736,000.00	1,095,735,998.74	1.26	100.00
210101	Үндсэн цалин	653,399,000.00	653,398,999.62	0.38	100.00
210102	Нэмэгдэл цалин	442,337,000.00	442,336,999.12	0.88	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,202,700.00	20,202,700.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,202,700.00	20,202,700.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,667,900.00	115,667,576.47	323.53	100.00
210301	Гэрэл, цахилгаан	16,899,200.00	15,621,404.47	1,277,795.53	92.44
210302	Түлш, халаалт	67,407,700.00	69,977,120.00	(2,569,420.00)	103.81
210303	Цэвэр, бохир ус	31,361,000.00	30,069,052.00	1,291,948.00	95.88
2104	Хангамж, бараа материалын зардал	26,927,900.00	26,847,767.32	80,132.68	99.70
210401	Бичиг хэрэг	4,160,000.00	4,641,800.00	(481,800.00)	111.58
210402	Тээвэр, шатахуун	16,245,400.00	14,360,000.00	1,885,400.00	88.39
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,800,000.00	1,478,312.32	1,321,687.68	52.80
210405	Хог, хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	272,500.00	240,000.00	32,500.00	88.07
210406	БҮТЭЗҮЙЛС	3,450,000.00	6,127,655.00	(2,677,655.00)	177.61
2105	Нормативт зардал	50,177,100.00	50,175,089.16	2,010.84	100.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,449,900.00	2,447,919.16	1,980.84	99.92
210502	Хоол хүнс	47,727,200.00	47,727,170.00	30.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,341,200.00	26,340,050.00	1,150.00	100.00
210601	Багаж, техник хэрэгсэл	8,800,000.00	8,609,600.00	190,400.00	97.84
210604	Урсгал засвар	17,541,200.00	17,730,450.00	(189,250.00)	101.08
2107	Томилголт, зочны зардал	1,585,100.00	1,585,100.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	1,585,100.00	1,585,100.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,774,800.00	6,774,656.50	143.50	100.00
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,755,100.00	1,755,099.50	0.50	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	172,200.00	172,064.00	136.00	99.92
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	80,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,644,500.00	4,644,500.00	-	100.00
210807	Газрын төлбөр	123,000.00	122,993.00	7.00	99.99
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,498,750.00	1,250.00	99.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,498,750.00	1,250.00	99.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,827,100.00	53,827,100.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,827,100.00	53,827,100.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,617,100.00	52,617,100.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,210,000.00	1,210,000.00	-	100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,399,739,800.00	1,399,654,788.19	85,011.81	99.99
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,397,739,800.00	1,397,654,788.19	85,011.81	99.99
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,397,739,800.00	1,397,654,788.19	85,011.81	99.99

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	34,400,000.00
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	-	34,400,000.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	34,400,000.00
210	БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	34,400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	26,900,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	-	16,900,000.00
210604	Урсгал засвар	-	10,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,500,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	34,400,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	34,400,000.00
131103	ЗГНС, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	24,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,000,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь / цаашид Сэлэнгэ аймаг дахь ШШГГ гэх/ “Байгууллагын соёлыг төлөвшүүлж, ахлагчийн манлайллыг дэмжих” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ нь үйл ажиллагааныхаа чиглэлийг дараах байдлаар тодорхойлж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалах, энэхүү үүргийг бүрэн хэрэгжүүлэх,
- Цагдан хорих, таслан сэргийлэх үйл ажиллагааг хүний эрхийг дээдлэн, хүний амьдрах эрүүл ахуйн шаардлага, стандартад нийцүүлэн хуулийн дагуу хэрэгжүүлж ажиллах,
- Хорих болон хорихоос өөр төрлийн ялыг албадан эдлүүлэх, сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, эрүүгийн ялын зорилтыг хангах,
- Иргэний, захиргааны зөрчлийн болон эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын анги, салбар нэгжийн барилга байгууламж, ахуй нөхцөлийг сайжруулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, баривчлагдсан этгээд, албадан эмчлүүлэгч, хоригдлын хоногийн хоол хүнсээр хангах, хоногт авбал зохих илчлэг норм”-ыг шинэчлэн баталсан гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ШШГЕГ-ын Хяналт шалгалт, дотоод аудитын газраас хяналт хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд тайлант онд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ШШГЕГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг баталсан байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 104,359.0 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	188.0	188.00	-
Авлага	-	4,620.0	4,620.0
Бараа материал	58,573.3	34,459.3	(24,114.0)
Үндсэн хөрөнгө	1,233,226.7	1,357,079.7	123,853.0
Нийт хөрөнгө	1,291,988.0	1,396,347.0	104,359.0
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,291,988.0	1,396,347.0	104,359.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,291,988.0	1,396,347.0	104,359.0

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлага данс 4,620.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь тайлант онд аймгийн ЗДНХ-ийн зардлаас нэмэлт санхүүжилтийн дансанд хуваарилсан хөрөнгө (Аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/621 дүгээр захирамжаар Сүхбаатар суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 4 эгнээ автозамын ажлаар тус байгууллагын эзэмшлийн хашааг татан буулгах, шинээр барихад гарсан зардлыг олгосон.) -ийг зарцуулалгүйгээр оны эцэст татан төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэснээс,
- Бараа материалын дансны үлдэгдэл 34,459.3 мянган төгрөг болж 24,114.0 мянган төгрөгөөр буурсан нь ШШГГГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/159 дүгээр тушаалаар нийт 14,859.9 мянган төгрөгийн үнэтэй 19 ширхэг цахим гав, 12 дугаар сарын 23-ны өдрийн А/343 дугаар тушаалаар нийт 11,028.3 мянган төгрөгийн аж ахуйн болон бусад

хангамжийн материалыг акталж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,357,079.7 мянган төгрөг болж 123,853.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 25,140.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 98,868.4 мянган төгрөг (*75,900.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 20,277.5 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 2,690.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж*)-ийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсан, ТӨБЗГ-ын 2024 оны 584, 788 дугаар тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 83,139.4 мянган төгрөг (*62,000.0 мянган төгрөгийн 3 тээврийн хэрэгсэл, 17,323.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,261.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 2,555.0 мянган төгрөгийн программ*) -ийн хөрөнгийг дахин үнэлж, орлогоор бүртгэсэн болон 83,294.8 мянган төгрөгийн элэгдлийг нэмж байгуулсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газар нь 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 953,404,2 мянган төгрөгөөр, өөрийн орлогоос 2,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр тооцон нийт зардлыг 955,404.2 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар нэмэгдүүлж баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 323,300.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 534.8 мянган төгрөг,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 22,256.5 мянган төгрөг,
- Хангамж, бараа материалын зардлыг 41,921.5 мянган төгрөг,
- Нормативт зардлыг 41,426.1 мянган төгрөг,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 22,385.0 мянган төгрөг,
- Томилолт, зочны зардлыг 5,316.0 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 2,959.8 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 2,500.0 мянган төгрөг,
- Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлыг 9,080.7 мянган төгрөг зэрэг нийт 148,380.4 мянган төгрөгөөр бууруулж **1,130,324.6** мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 269,415.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн төсвийн тодотгол, зохицуулалт хийж нийт **1,399,739.8 мянган төгрөг** (*Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 123,052.1 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 8,083.2 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 31,777.9 мянган төгрөгөөр, хангамж,*

бараа материалын зардлыг 7,750.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 22,484.9 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 19,000.0 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 1,600.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 500.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,000.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлыг 53,167.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.) -өөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,397,739.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, нийт 1,399,739.8 мянган төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,397,739.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 2,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт 1,399,739.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 1,399,654.8 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 85.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,399,654.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай тайлагнагдсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	1,336,398.1	1,336,313.1	85.0	99.9
2	Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа	8,340.0	8,340.0	-	100.0
3	Холбооны суваг ашигласны төлбөр	1,174.6	1,174.6	-	100.0
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	53,827.1	53,827.1	-	100.0
	Дүн	1,399,739.8	1,399,654.8	85.0	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газар нь нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 39,020.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн 34,400.8 мянган төгрөгийг зарцуулж, жилийн эцэст 4,620.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна. Үүнийг тодруулбал:

- ШШГЕГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/63 дугаар тушаалаар хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөрийн биелэлтийг хангах ажлын хүрээнд 10,000.0 мянган төгрөг,

- Аймгийн ИТХ-ын Ажлын албаны даргын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/06 дугаар тушаалаар тус газрын Цагдан хорих байрны эрчим хүчний хэвийн үйл ажиллагааг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авахад 16,900.0 мянган төгрөг,
- Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/100 дугаар захирамжаар ЗДНХ-өөс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Хойд бүсийн аварга шалгаруулах тэмцээн”-ийн шагналын зардалд 7,500.0 мянган төгрөг, 12 дугаар сарын 24-ний өдрийн А/621 дүгээр захирамжаар Сүхбаатар суманд УТХО-аар хийгдсэн 4 эгнээ автозамын ажлаар тус газрын эзэмшлийн хашааг татан буулгах, шинээр барихад гарсан зардлын 4,620.0 мянган төгрөг.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус газар нь тайлант онд хоригдол, хоригдогч нарын хоол хүнсний материалын худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

/ мянган төгрөгөөр /

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам / Тендер шалгаруулалтын арга
1	Хоригдол, хоригдогч нарын хоол хүнсний материал нийлүүлэх	26,000.0	26,000.0	Харьцуулалт
	Нийт дүн	26,000.0	26,000.0	

Хоол хүнсний материалын бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг цахимаар 2 удаа зохион байгуулсан боловч оролцогч санал ирүүлээгүй тул “Алтантариа” ХК, “Номун Сэлэнгэ” ХХК, “Галил-Этоос” ХХК, иргэн С.Майнбаяр, Ц.Оюун-Эрдэнэ нартай тус тус гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/115 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,122,208.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,222.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Бичиг хэргийн зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,*
- *Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулан төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж ажилласан байна.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ нь шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 28 төрлийн 169 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус газрын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 2 зөвлөмжийн биелэлтийг холбогдох баримтын хүрээнд тулган шалгахад 100 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	382.0	2	382.0	100
Нийт дүн	2	382.0	2	382.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг **дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна.** Үүнд:

1. Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн системээр төсвийн төлөвлөлтийг хийж гүйцэтгэдэг атал ХЗДХ-ийн сайдын 2022 оны А/128 дугаар тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 3/2881 дүгээр албан бичгийг үндэслэн хөрөнгөнд бүртгэлгүй төсвийн төлөвлөлтийн программын үйлчилгээний төлбөр, хөгжүүлэлтэд 4,000.0 мянган төгрөгийг “Даталанд технологи” ХХК-д шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2. Сүхбаатар суманд нийтийн тээврийн тогтмол үйлчилгээ үзүүлдэггүй атал ШШГЕГ-ын даргын 2023 оны 06/2113 дугаар албан бичгийн дагуу өдрийн 3.0 мянган төгрөгөөр тооцож, бүх албан хаагчдын унааны зардлын нөхөх төлбөрт нийт 18,639.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.2 дахь “**Нийтийн тээврийн тогтмол үйлчилгээтэй хот суурин газарт ажиллаж байгаа энэ журмын 8.1-д зааснаас бусад төрийн албан хаагч нь ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зайлшгүй шаардлагатай бол нийтийн тээврийн унааны зардлын 50 хувийг байгууллагаас нь нөхөн олгоно.**” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Тайлант оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд ШШГЕГ-аас хуваарилсан нэмэлт санхүүжилтийг 4,620.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан алдааг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 766.1 мянган төгрөгийн 1 зөрчил¹ илэрч зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.1 Албан шаардлага

1. ШШГЕГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/63 дугаар тушаалаар “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон нэмэлт санхүүжилтээс тус газрын УАЗ-374195 маркийн автомашиныг засварлахад 766.1 мянган төгрөгийн сэлбэг худалдан авч зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэлт санхүүжилтийг дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрт тусгагдсан зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэмэлт төсвийн санхүүжилтийг дутуу тайлагнасан.	1	4,620.0	1	4,620.0			1	4,620.0				
Дүн	1	4,620.0	1	4,620.0	-	-	1	4,620.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Нэмэлт санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан.	1	766.1			1	766.1							
Дүн	1	766.1	-	-	1	766.1	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-